

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3

*1.Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар
2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 3

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Т.Доржханд,
Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, Ж.Эрдэнэбат.

Нэг.Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн хувийн ирцтэйгээр 19 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 16-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
19 цаг 56 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ энэ оройн мэнд хүргэе.

Ирц бүрдсэн байна. Маргааш хийхээр төлөвлөж байсан хурлаа наашлуулаад өнөөдөр нэгмөсөн тогтоолынхоо төслийг гүйцээчихье гэж ярьсны дагуу ирц бүрдсэн учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 1 сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын 24 оны 1 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Байнгын хороогоор эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Би Байнгын хорооны танилцуулгыг нь хийгээдэхье.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 24 оны 1 сарын 16-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 1 сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй зарим засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг эцсийн хэлбэрээр бэлдээд та бүхэнд тараасан байгаа. Сая Сараа гишүүн 2 найруулгын шинжтэй санал гаргасан тээ? Тэрийгээ оруулаад засчихъя. Өөр саналтай, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй юу.

Тэгвэл Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Чуулганы хуралдаанд Сарангэрэл гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулчих уу?

Баярлалаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууслаа. Гишүүддээ талархал илэрхийлье.

19.59 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

